# ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 2 сарын 10 өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолоор баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-ыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү төлөвлөгөөнд заагдсан ажил, арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба (Л.Нямгэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД О.АЛТАНГЭРЭЛ

СБТ 10399

*Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 10 өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт*

СБТ 10399

## ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ (Бодлогын үндэслэл) | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүнгийн үзүүлэлт | | Санхүүжилт | Хугацаа | Хэрэгжүүлэгч | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суурь түвшин | Зорилтот түвшин | | | Үндсэн | Хамтран |
| **Нэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд (ГХЗУСТХ 14.2, ГХЗУСТХ 15.1):** | | | | | | | | | |
| 1.1. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар дундын стратеги төлөвлөгөө боловсруулах. (ГХЗУСТХ 17.1.2.) | Боловсруулж батлуулсан стратеги төлөвлөгөөний тоо | Тоо | 0 | 1 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХУСАЗЗАА, ЦЕГ, НГХУСАЗСЗ | Зөвлөлийн гишүүд |
| 1.2. | Салбар дотоодод болон эрхлэх асуудлын хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, хариуцсан албан хаагч томилон ажиллуулах | Төлөвлөгөө батлуулж хэрэгжүүлсэн зөвлөлийн гишүүдийн тоо | Тоо | 38 | 38 | Үйл ажиллагааны зардлаас | I улирал | Зөвлөлийн гишүүд | Холбогдох байгууллага |
| 1.3. | Төрийн албаны анхан дунд шатан дахь хүнд суртлыг арилгах, таслан зогсоох, иргэд хувийн хэвшлийг чирэгдүүлж, авлига үүсгэх нөхцөл бүрдүүлж байгаа үйл ажиллагаа, чиг үүргийн талаар дүгнэлт хийж, эрсдлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх | Зохион байгуулсан ажил, арга хэмжээ | Тоо | - | 38 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | Зөвлөлийн гишүүд | АТГ |
| 1.4. | Төрийн байгууллага, албан тушаалтны хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхол, хууль дээдэлсэн хандлага төлөвшүүлэх, бэхжүүлэх чиглэлээр эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авч, ажиллах | Зохион байгуулсан ажил, арга хэмжээ | Тоо | - | 38 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХУСАЗЗАА, ДХИС, ХЗҮХ | Зөвлөлийн гишүүд |
| 1.5. | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх. (ГХЗУСТХ 17.1.8, ХТТХ 51) | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ | Тоо | - | 1 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХУСАЗЗАА | Зөвлөлийн гишүүд |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хийгдсэн эсэх. | | | | | | | |
| 1.6. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах журмыг эцэслэн боловсруулж, батлуулах | Хууль тогтоомжийн тухай хуулийг баримтлах | Тоо | - | 1 | Үйл ажиллагааны зардлаас | I улирал | СЯ, ГХУСАЗЗАА | ХЗДХЯ |
| 1.7. | Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах аргачлалыг баримтлах | Тоо | - | 5 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХУСАЗЗАА | Дэд зөвлөл |
| 1.8. | Ерөнхий боловсролын 10-12 дугаар ангийн сурагчид, их, дээд сургуулийн эрх зүйн бус мэргэжлийн ангийн 1, 2 дугаар дамжааны оюутнууд, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад эрх зүйн мэдлэг олгох албан бус сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулах (МУЗГҮАХ 4.2.1.9) | Сургалтад хамрагдсан оюутан, суралцагчийн тоо | Тоо | - | 5000 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | БЯ, ХЗДХЯ, | ХЗДХЯ, ГХУСАЗЗАА, АТГ, ЦЕГ, ХЗҮХ, МҮОНРТ, МӨХ, ДХИС, ХЗТТ |
| 1.9. | Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн криминологи судалгаа хийх ажлыг зохион байгуулах | Гүйцэтгэсэн криминологи судалгааны тоо | Тоо | - | 5 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХУСАЗЗА, ДХИС, ХЗҮХ | УДШ, УЕПГ, ЦЕГ, ЭМЯ,ЗТЯ, БОУАӨЯ, АТГ, МКХ, БХЯ |
| 1.10. | Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох нэгдсэн сангийн ашиглалт, хүртээмжийг нэмэгдүүлж, сайжруулах | Нэмэлтээр холбогдсон прокурор, хууль сахиулах байгууллага | Тоо | - | 10 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ХЗДХЯ, УЕПГ, ЦЕГ | ГХУСАЗЗАА, УДШ, ШШЕГ, Холбогдох байгууллага |
| 1.11. | “Гэмт хэргийн цагаан ном-2024” эмхтгэлийг бэлтгэн гаргаж, олон нийтийн хүртээл болгох | Холбогдох эрх зүйн зохицуулалт, шинжлэх ухааны арга зүй | Тоо | - | 300 | Үйл ажиллагааны зардлаас | II улирал | ГХУСАЗЗАА, ДХИС | АТГ, УДШ, УЕПГ, ТЕГ, ЦЕГ, ШШГЕГ, ШШЕГ, ДХИС |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.12. | Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл байгуулагдсаны түүхт 60 жилийн ойн арга хэмжээг угтаж гишүүн бүр хэрэгцээ шаардлага, судалгаа, ач холбогдлыг харгалзаж 1 онцлог ажил, арга хэмжээ (төсөл) хэрэгжүүлэх | Хэрэгүүлсан ажил, арга хэмжээ | Тоо | - | 38 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | Зөвлөлийн гишүүд | Холбогдох байгууллага |
| 1.13. | Салбар зөвлөлийн гишүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт, зарцуулалт, тайлагнахтай холбоотой мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх | Санхүү, татвар, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн дагуу | Тоо | - | 22 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ҮАГ | Холбогдох байгууллага |
| 1.14. | Гадаадад гэмт хэргийн хохирогч болсон иргэдэд үзүүлж буй эрх зүйн болон санхүүгийн дэмжлэг туслалцааг нэмэгдүүлэх | Холбогдох эрх зүйн зохицуулалтыг баримтлах | Тоо | - | 8 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХЯ | Холбогдох байгууллага |
| 1.15. | Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх | Аргачлал болосруулж, хүргүүлэх | Тоо | - | 100 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | АТГ | ГХУСАЗЗ, Салбар зөвлөл |
| 1.16. | Иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд цахим технологи, программ хангамж нэвтрүүлэх ажлыг нэмэгдүүлэх, гадаад улсад туршлага судлах ажлыг зохион байгуулах, нэвтрүүлэх | Хэрэгжүүлсэн сайн туршлага | Тоо | - | 2 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | НИТХ, ГХУСАЗЗАА, ХББОСЯ | ЦХИХХЯ, ЗТЯ, УЕПГ, ЦЕГ |
| **Хоёр. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлийн хүрээнд:** | | | | | | | | | |
| **2.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:** | | | | | | | | | |
| 2.1.1. | Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрыг шинээр болон бүсчлэн байгуулах ажлыг үргэлжлүүлэх, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах (МУЗГҮАХ 4.4.1.9) | Холбогдох хууль тогтоомжийг баримтлах | Тоо | - | 2 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ХЗДХЯ, ЭМЯ, ШШГЕГ | ГХУСАЗЗА, НГХУСАЗСЗ, Холбогдох байгууллага |
| 2.1.2. | Согтуурах, мансуурах донтой болон дэлгэцэд донтох өвчний хор уршигтай тэмцэхэд чиглэсэн тусламж, үйлчилгээний үзүүлэх сайн дурын "Төв" байгуулах | Холбогдох хууль тогтоомж, эмчилгээ | Тоо | 1 | 4 | Үйл ажиллагааны зардал, бусад | Жилдээ | ЭМЯ, НИТХ, ГХУСАЗЗАА | НГХУСАЗСЗ, Холбогдох байгууллага |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчилгээний стандартыг баримтлах | | | | | | | |
| 2.1.3. | Зэрлэг байдлаар ургаж буй мансууруулах үйлчилгээтэй ургамлыг устгах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тархац тогтоогдсон аймгийн нутаг дэвсгэрт зохион байгуулах (МУЗГҮАХ 4.4.1.9) | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 90 | Үйл ажиллагааны зардлаас | II, III улирал | ГХУСАЗЗАА | ХЗДХЯ, БОУАӨЯ, ЦЕГ, ОБЕГ, БХЯ, Салбар зөвлөл |
| 2.1.4. | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагад шаардлагатай программ хангамж, техник хэрэгсэл, багаж нийлүүлэх (МУЗГҮАХ 4.4.1.9) | Тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц, гүйцэтгэлээр (багц) | Тоо | - | 3 | Үйл ажиллагааны зардлаас | I, II улирал | ГХУСАЗЗАА | ЦЕГ, ШШГЕГ, ШШЕГ, Үндэсний хороо |
| 2.1.5. | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн сэжигтэй хүнийг таних, илрүүлэх, шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээний мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | Тоо | - | 500 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХУСАЗЗАА, ЦЕГ | Үндэсний хороо |
| **2.2.Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:** | | | | | | | | | |
| 2.2.1. | Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллах, дэмжлэг үзүүлэх (МУЗГҮАХ 4.2.1.8) | Хамтран ажилласан төрийн бус байгууллагын тоо | Тоо | - | 5 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХУСАЗЗАА, Дэд зөвлөл | Төрийн бус байгууллага |
| 2.2.2. | Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах (МУЗГҮАХ 4.2.1.8) | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | Тоо | - | 500 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХУСАЗЗАА, Дэд зөвлөл | Холбогдох байгууллага |
| 2.2.3. | Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч иргэдийг зохих сургалтад хамруулж, ажлын байраар хангах чиглэлээр холбогдох арга хэмжээ авах (МУЗГҮАХ 4.2.1.8) | Сургалтад хамруулсан хохирогчид | Тоо | - | 50 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГБХНХЯ | ГБХЗХГ, ЦЕГ, Төрийн бус байгууллага |
| **2.3.Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:** | | | | | | | | | |
| 2.3.1. | Бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрт тусгасан аливаа зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох агуулгыг нягтлах, үр дүнд үнэлгээ хийх | Аргачлалын дагуу хийх (багц) | Тоо | - | 1 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | БЯ | ГБХНХЯ, ГБХЗХГ, Салбар зөвлөл, |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Холбогдох байгууллага |
| 2.3.2. | Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн сэтгэцийн эрүүл мэнд, нөлөөлж буй хүчин зүйлс, түүнийг арилгах, үзүүлэх тусламж үйлчилгээ, хүрээмжийг нэмэгдүүлэх | Салбар шинжлэх ухааны судалгаанд үндэслэх | Хувь | - | 75 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ЭМЯ | Салбар зөвлөл, ШШГЕГ, Холбогдох байгууллага |
| 2.3.3. | Хүчирхийллийг илэрхийлж, сурталчилсан агуулга бүхий соёл, урлагийн арга хэмжээ, аливаа уран бүтээл, утга зохиолыг нийтэд түгээхээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хязгаарлалт тогтоох, үр дүнг тооцох | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 80 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ЦХИХХЯ, ССАЖЗЯ | МҮОНРТ, Холбогдох байгууллага |
| 2.3.4. | Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтэд холбон зуучлах ажлыг тогтмолжуулах | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 60 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГБХНХЯ | НИТХ, Холбогдох байгууллага |
| **2.4.Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:** | | | | | | | | | |
| 2.4.1. | Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг аймгийн сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, хэсгийн төлөөлөгч, экологийн асуудал хариуцсан байцаагч, шинжээч, хэсгийн байцаагч (хуулиар үүрэг хүлээсэн бусад субъект) нарыг чадавхжуулах салбар дундын зөвлөгөөн зохион байгуулах | Ажлын явц, гүйцэтгэлээр | Тоо | - | 1 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХУСАЗЗАА, Салбар зөвлөл | БОУАӨЯ, Дэд зөвлөл, МӨХ, Холбогдох байгууллага |
| 2.4.2. | Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулах (газар, газрын хэвлий, хөрс, ойн сан, усны нөөц, амьтан, ургамал, байгалийн дагалдах баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, хохиол нөхөн төлүүлэх) арга хэмжээ авах | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 85 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | БОУАӨЯ, ЦЕГ | Дэд зөвлөл |
| 2.4.3. | Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд “Байгалиа хамгаалъя” олон нийтийг соён гэгээрүүлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | | 90 | Үйл ажиллагааны зардлаас | II улирал | ГХУСАЗЗАА | ССАЖЗЯ, Дэд зөвлөл, Холбогдох байгууллага |
| 2.4.4. | Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах | Удирдамж, хөтөлбөрийн дагуу зохион байгуулах | Тоо | - | 100 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХУСАЗЗАА | Дэд зөвлөл, Холбогдох байгууллага |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.5.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:** | | | | | | | | | |
| 2.5.1. | Монгол Улсын үхэр сүргийг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах ажлыг үргэлжлүүлэх | Бүртгэлийн системийн дагуу | Тоо | - | 200,000 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ХХААХҮЯ | Салбар зөвлөл |
| 2.5.2. | Маршрутын бус замаар /хулгайн замаар/ нийслэлд мал, мах болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэн нэвтрүүлж байгаатай холбогдуулан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтарсан хяналт шалгалт зохион байгуулах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Хувь | - | 85 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ХХААХҮЯ, ЦЕГ | НИТХ |
| **2.6. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:** | | | | | | | | | |
| 2.6.1. | Цахим орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, зохистой хэрэглээг бий болгох талаар соён гэгээрүүлэх арга хэмжээ авах, аюулгүй байдал, ёс суртахуунд нь сөргөөр нөлөөлөхүйц агуулга бүхий мэдээ, мэдээллийг хязгаарлах, таслан зогсоох чиглэлээр үүрэн холбооны оператор, интернэтийн үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран ажиллах | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 85 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ЦХИХХЯ | БЯ, ГБХНХЯ, ГБХЗХГ, Холбогдох байгууллага |
| 2.6.2. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хиймэл оюун ухаан, цахим технологийг түлхүү ашиглах, инновац нэвтрүүлэх | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 85 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ЦХИХХЯ, ГХУСАЗЗАА, НИТХ | ЦЕГ, Холбогдох байгууллага |
| 2.6.3. | Цахим хэрэглээний донтолт, түүний хор уршиг, цахим халдлагаас хамгаалах болон хүүхдийн насны онцлогт тохирсон цахим хэрэглээг хяналттай, хязгаартай байдлаар нэвтрүүлэх, бодлогыг боловсролын бүх шатанд хэрэгжүүлэх | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 85 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | БЯ, ГБХНХЯ, ЦХИХХЯ | ЭМЯ, ГБХЗХГ, Холбогдох байгууллага |
| **Гурав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэлийн хүрээнд:** | | | | | | | | | |
| 3.1. | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд авто зам, замын байгууламжийн стандарт, шаардлага, технологийн горимд тавих хяналт, хариуцлага, түүний үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авах | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 85 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ЗТЯ, Салбар зөвлөл | УЕПГ, ЦЕГ |
| 3.2. | Ой, ан, байгалийн ургамлын ашиглалт, хамгаалалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийх | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 85 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | БОУАӨЯ | ЦЕГ, Салбар зөвөл |
| 3.3. | Иргэдийн оролцоотой замын хөдөлгөөний хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд E-Police цахим програм ашиглан замын хөдөлгөөний | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 90 | Үйл ажиллагааны зардлаас | I улирал | ЦЕГ | НИТХ, Холбогдох байгууллага |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дүрмийн хэрэгжилтийг эрчимжүүлж, бүрэн ашиглалтад оруулах | | | | | | | | |
| 3.4. | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болон цахим хэлбэрээр үйлдэгдэж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 85 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ЦЕГ, НИТХ | Салбар зөвлөл, холбогдох байгууллага |
| 3.5. | Замын хөдөлгөөний зохион байгуулалт, аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд гэрээт болон олон нийтийн цагдаа, олон нийтийн байцаагчийг ажиллуулах | Ажлын явц, үр дүнгээр | Хувь | - | 75 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | Салбар зөвлөл | ЦЕГ |
| 3.6. | Хорих ял эдлээд суллагдсан хүнийг хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор нутгийн захиргааны байгууллага болон төр, төрийн бус байгууллагуудтай хамтран ажлын байраар хангах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 20 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГБХНХЯ, ГХУСАЗЗАА, ШШГЕГ, | Салбар зөвлөл |
| 3.7. | Хорих ялаас өвчний учир чөлөөлөгдсөн хүн дахин гэмт хэрэг, зөрчил үйлдсэн эсэхийг улсын хэмжээнд сүүлийн 3 жилийн байдлаар судалж, дүнг танилцуулах | Судалгааны тоо | Тоо | - | 1 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | УЕПГ, ЦЕГ, ШШГЕГ | Салбар зөвлөл, холбогдох байгууллага |
| **Дөрөв. Соён гэгээрүүлэх чиглэлээр:** | | | | | | | | | |
| 4.1. | Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон соён гэгээрүүлэх чиглэлээр инфографик, шторк, контент болон цуврал нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд түгээх | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 80 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | МҮОНРТ, ГХУСАЗЗАА | Зөвлөлийн гишүүд |
| 4.2. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэтгүүлчдэд зориулсан сургалт зохион байгуулах | Удирдамж, хөтөлбөрийн дагуу | Тоо | 30 | 40 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХУСАЗЗАА | Холбогдох байгууллага |
| 4.3. | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн хуулийг сурталчлах, энэ талаарх иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнд зөвлөгөө, мэдээлэл өгөх тусгай дугаарын утас ажиллуулах | Зөвлөгөө, мэдээлэл өгсөн иргэд | Тоо | - | 5000 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ХЗҮХ | ГХУСАЗЗАА, МӨХ, Холбогдох байгууллага |
| 4.4. | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ төлбөргүйгээр яаралтай нийтэлж, нэвтрүүлэх | Нийтэлж, нэвтрүүлсэн мэдээний тоо | Тоо | - | 100 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | МҮОНРТ | Холбогдох байгууллага |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.5. | Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагчдыг чадавхжуулах | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | Тоо | - | 30 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | УЕПГ, ЦЕГ, ДХИС | ГХУСАЗЗАА, УДШ, АТГ, ТЕГ, ЦЕГ, ШШГЕГ |
| 4.6. | ЕБС-ийн сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор "Өсвөрийн сэргийлэгч" бүлгэмийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үе шаттай тэмцээн зохион байгуулах | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 90 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХУСАЗЗАА, ЦЕГ, ДХИС, НИТХ, МҮОНРТ | ХЗДХЯ, БЯ, ГБХНХЯ, ГБХЗХГ, Салбар зөвлөл |
| 4.7. | Төрийн алба хаагчдад төрийн, байгууллагын болон хувь хүний нууцтай холбоотой хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах | Сургалтад хамрагдсан албан хаагчид | Тоо | - | 100 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ТЕГ | Холбогдох байгууллага |
| 4.8. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл үзүүлж байна "Сэргийлэгч" нэвтрүүлгийг бэлтгэн, олон нийтэд хүргэх | Олон нийтэд хүргэсэн нэвтрүүлэг | Тоо | 8 | 18 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХУСАЗЗАА | Холбогдох байгууллага |
| 4.9. | "Ногоон гэрэл-Цагаан шугам", "Замын хөдөлгөөний цагаан толгой" хөтөлбөрийг шинэчлэх, улсын хэмжээнд зохион байгуулах | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 85 | Үйл ажиллагааны зардлаас | II улирал | БЯ | ЦЕГ, ГБХЗХГ, Салбар зөвлөл |
| 4.10. | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд мэргэшсэн болон иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, салбар зөвлөлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх | Хамтран зохион байгуулсан ажил | Тоо | - | 22 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ГХУСАЗЗАА, МХХ | Салбар зөвлөл, Төрийн бус байгууллага |
| 4.11. | "Орон нутгийн зам- хөдөлгөөний соёл" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах | Ажлын явц, гүйцэтгэлээр | Хувь | - | 85 | Үйл ажиллагааны зардлаас | Жилдээ | ЗТЯ, ГХУСАЗЗАА, ЦЕГ, | Салбар зөвлөл |

---oOo---